



ШИНЭ ҮЕ СУРГУУЛЬ

ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

(АЙБИ ДИПЛОМ ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭХ ЖУРМЫН ХАМТ)

Шинэчилсэн: 2018 оны 3 сар
Дахин хянах: 2019 оны 6 сар

ТАНИЛЦУУЛГА

“Шинэ үе” сургууль анх 2003 онд Монгол улсын ардын багш Ү.Маамын санаачлагаар байгуулагдсан. Бид 2005 оноос Математик - Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалттай сургууль болсон. Та бүхнийг манай сургуульд элсэн орохыг урьж байна.

“Шинэ үе” сургууль нь 2016 оноос эхлэн олон улсын АйБи програмыг хэрэгжүүлэхээр болсон. Бид ирэх хоёр жилийн дотор дэлхийн АйБи сургуулиудын эгнээнд жагсахаар зорьж байна. АйБи нь 4 төрлийн сургалтын хөтөлбөрийг санал болгодог: бага ангийн ПиУайПи хөтөлбөр, дунд ангийн ЭмУайПи хөтөлбөр, АйБи дипломын хөтөлбөр ба мэргэжилд бэлдэх IB карьерийн хөтөлбөр. Бид IB програмын хөтөлбөр нь суралцагчдын амьдрал болон тэдний гэр бүлд томоохон өөрчлөлт бий болгоно гэдэгт итгэж байна.

Горилогч сургууль нь АйБи сургууль болж чадах эсэх нь баталгаагүй бөгөөд АйБи хөтөлбөрийн талаар илүү их мэдээлэл авахыг хүсвэл <http://www.ibo.org> хаягаар зочилоорой.

ЭЛСЭХ ЖУРАМ

Манай сургуульд 1-р ангиас элсэн орохыг хүсвэл:

Жил бүрийн 1-р ангид элсэхээр бүртгүүлсэн сурагчдад зориулж бэлтгэл бүлэгтээ 3 долоо хоногийн сургалт зохион байгуулдаг. Тухайн бэлтгэл сургалтанд хамрагдах нь манай сургуульд элсэн ороход давуу талтай.

Бэлтгэл бүлгийн хуваарь - www.shineue.edu.mn/admissions/preschool

Манай бэлтгэл сургалтанд хамрагдсан болон бэлтгэл сургалтанд хамрагдаагүй элсэлтийн шалгалтанд бүртгүүлсэн хүүхдүүдээс 5-р сард нэгдсэн байдлаар хүүхдийн ерөнхий чадварын сорил авна. (шалгалтын товыг сайтаар дамжуулан урьдчилан зарлана.) Уг сорил нь хүүхдийн сурах чадварыг тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү сорилын дүнг үндэслэн шалгаруулж авна.

1-р ангид элсэгч нь тухайн ондоо 6 нас хүрэх эсвэл 6 нас хүрсэн байх шаардлагатай.

Бусад сургуулиас шилжин ирэхийг хүсвэл:

Манай сургуульд бусад сургуулиас шилжин ирэхийг хүссэн сурагч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Элсэгч нь түвшин тогтоох шалгалтыг монгол хэл, математик, англи хэл гэсэн гурван хичээлээр заавал өгнө. Монгол хэл, математикийн шалгалт нь БСШУСЯ-наас гаргасан боловсролын стандартын дагуу байна. Харин англи хэлний шалгалт нь манай сургуулийн хөтөлбөрийн дагуу байна. Эдгээр шалгалтанд 70%-аас доошгүй дүн авсан сурагчид элсэх эрхтэй болно.

2. Шалгалтын комисс шалгалтанд орсон сурагчидтай ярилцлага хийх шаардлагатай гэж үзвэл тухайн сурагчийн эцэг эх, асран хүмүүжүүлэгчтэй нь ярилцлага хийсний дараа эцсийн дүнг гаргаж сургуульд элссэн эсэхийг мэдэгдэнэ.
3. Сургуульд элссэн сурагчид шаардагдах бичиг баримтыг бүрэн бүрдүүлнэ. (Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг доор хавсаргасан болно)
4. Сурагчдыг элсүүлэхдээ биеийн болон оюуны чадамжийг бид харгалзан үзэх ба манай сургуулийн хөтөлбөрийн цар хүрээ, түвшинг эцэг эх, асран хамгаалагч нарт бүрэн тайлбарласны дараа элсүүлнэ.

”Шинэ үе” сургуульд элссэн тохиолдолд доорх бичиг баримтыг бүрдүүлнэ:

1. Сурагчийн төрсний гэрчилгээний хуулбар
2. Эцэг эхийн иргэний үнэмлэхний хуулбар
3. Сурагчийн анкет бөглөх (3x4 зураг хэрэгтэй)
4. Эрүүл мэндийн хуудас бөглөх
5. Манай сургууль руу шилжиж байгаа бол сурагчийн хувийн хэрэг
6. Дүүргийн боловсролын цахим ESIS системд хуучин сургуулиас хасалт хийх
7. Сурагч гадаадын сургуулиас шилжин ирж байгаа бол сургуулийн үнэлгээний журмын дагуу гадаадын сургуулийн дүнг Монголын ЕБС-н үнэлгээ рүү шилжүүлнэ.
8. Суудал хадгалах төлбөр тушаах (энэ төлбөр нь сургалтын төлбөрийн нэг хэсэг болох ба СУРГАЛТЫН ТӨЛБӨР хуудаснаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу).

АйБи Диплом хөтөлбөрт элсэх журам:

- 11-р ангид элссэн байх
- Тус хөтөлбөрийн талаар бүрэн ойлголттой, төгсөх шалгуураа мэддэг байх
- Англи хэлний шаардлагыг биелүүлэх хэрэгтэй:

TOEFL Junior шалгалтын нийт онооны нийлбэр 750-с дээш ба шалгалтын бүрэлдэхүүн тус бүрийн оноо нь хамгийн багадаа:

Сонсгол (Listening Comprehension) – 245

Дүрэм ба найруулга (Language Form and Meaning) – 250

Уншиж ойлгох (Reading Comprehension) – 255

Жич: Шинэ үе сургуулийн АйБи Диплом хөтөлбөрт элсэн суралцахад нэмэлт төлбөр байхгүй. Харин 12-р ангиа төгсөх жил АйБи Диплом авах шалгалтанд бүртгүүлэх хураамжийг тухайн үед бүртгүүлэхдээ нэмж төлнө. (Төлбөрийн мэдээллийг [IB’s Assessment Fees and Services](#) хуудаснаас авна уу).

Эцэг эхийн үүрэг:

Сурагчдын сурлагын үнэлгээний түвшин нь эцэг эхээс хамааралтай бөгөөд эцэг эхийн хандлага нь хүүхдийн сурлага болон хүмүүжилд асар их нөлөөлдөг. Сурагчид амжилттай суралцахад багш эцэг эхийн хамтын ажиллагаа нэн чухал.

Хүлээлгийн жагсаалт:

Хэрэв тухайн ангид орон тоо үлдээгүй бол сурагчид хүлээлгийн жагсаалтанд орох боломжтой. Хүлээлгийн жагсаалтанд орохыг хүсвэл сургалтын менежерт хүсэлтээ гаргана.

Анги хуваарилалт:

Бид элссэн сурагчдын ангийн бүлгийн хуваарилахдаа ангийн сул орон тоо, сурагчийн элссэн огноо, сурагчийн нас зэргийг харгалздаг. Сурагчид анх элссэн бүлэгтээ төгстөлөө тогтвортой суралцснаар урт хугацааны нөхөрлөл үүсгэх эерэг нөлөөтэй. Манай сургууль нь олон анги, бүлгийн хамарсан үйл ажиллагаа идэвхтэй зохион байгуулж, нийгмийн харилцааг хөгжүүлдэг.

Журам хянан өөрчлөх явц:

Энэхүү журмыг хамгийн сүүлд хянан засварлаж өөрчилсөн өдрөөс хойшхи хоёр жил тутам дахин хянан өөрчилж байх болно. Хамгийн сүүлд энэхүү журмыг өөрчилсөн он, сар, өдөр уг журмын хуудас бүрийн баруун доод буланд тэмдэглээстэй байх ёстой.

Журамд оруулах аливаа өөрчлөлтийн талаархи санал санаачилгыг нийт багш нарын 70 хувиас доошгүй ирцтэй багш нарын хурлаар хэлэлцэн батлах ёстой. Багш нар тийнхүү журамд оруулахаар санал болгосон өөрчлөлтийг санал хураалтаар батална.

Тийнхүү баталсан засвар өөрчлөлтүүдийг сургуулийн захирал, сургалтын менежерүүд, хөтөлбөрийн зохиуцуулагч болон тэнхимүүдийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй сургуулийн захиргаа дахин хянан үзэж, бусад журам болон дотоодын хууль тогтоомжид үл харшлахаар байвал батална.

Журамд хамгийн сүүлд оруулсан аливаа засвар өөрчлөлт нь сургуулийн захиргаанаас өөрөөр шийдвэрлээгүй бол дараачийн хичээлийн жилээс эхлэн хүчин төгөлдөр болно.